Зүүн Ази болон Номхон далайн бүсийн эдийн засгийн төлөв

Эдийн засгийн сэргэлт сорилттой тулгараад байна.

2021 оны 9 дүгээр сар

ЗҮҮН АЗИ БОЛОН НОМХОН ДАЛАЙН БҮСЭД ЯМАР ҮЙЛ ЯВЦ ӨРНӨЖ БАЙНА ВЭ? ЯАГААД?

Эдийн засгийн сэргэлт суларлаа

Бүсийн өсөлтийн төсөөллийг 2.5% болгож өмнөх төсөөлөл (4.4%)-өөс бууруулаа. Улс бүрийн хувьд харилцан адилгүй байна.

Хязгаарлалтууд эдийн засгийн үйл ажиллагааг хумьж байна

Шинжлэх, мөшгөх, тусгаарлах гэх мэт стратеги нь 2020 онд үр дүнтэй байсан бол дельта хувилбарын эсрэг сул үр дүнтэй байна. Улс орнууд халдварыг хумихын тулд илүү хатуу арга хэмжээ авч байна.

Урт хугацааны өсөлтөд сөргөөр нөлөөлөв

ААН-үүд сарын орлогын 40 гаруй хувийг алдаж, бизнесийн харилцаа, холбоо гэх мэт үнэт баялгаа алдаж, хөрөнгө оруулалтаа хойшлуулж байна.

Ядуурал хадгалагдаж, тэгш бус байдал нэмэгдэнэ.

2021 онд 24 сая орчин хүн ядуурлаас гарч чадахгүй, ядуу иргэдийн орлого буурч хоол хүнсний аюулгүй байдал, боловсролын асуудал үүсэх



Вакцинжуулалт хүндрэлтэй байна.

Бүсийн олон улс орнууд 2022 оны эхний хагаст хүн амынхаа 60 хувийг вакцинжуулах төлөвтэй. Гэхдээ халдварыг зогсоохын тулд илүү өндөр хувийг вакцинжуулах шаардлагатай.



Эрүүл мэндийн салбарыг бэхжүүлэх шаардлагатай

Шинжлэх, мөшгөх, тусгаарлах арга хэмжээг үргэлжлүүлэхийн зэрэгцээ цар тахал удаашрах эрсдэлд үндэслэн ЭМ-ийн салбарыг бэхжүүлэх шаардлагатай.

1. Монгол: Вакцинжуулалтын хувь хэмжээ өндөр байна



Source: Official data collated by Our World in Data. This data is only available for countries which report the breakdown of doses administered by first and second doses in absolute numbers.

CC BY

2. Вакцинжуулалтыг үргэлжүүлэх, эрүүл мэндийн салбарын бэлэн байдлыг хангах нь чухал байна

3. Засгийн газрын дэмжлэг нь 2020 онд хямралын нөлөөг сааруулсан бол 2021 онд өсөлтийг дэмжиж байна.



4. Монголын эдийн засаг 2021 онд сэргэх боловч өсөлтийн төсөөллийг бууруулаа.



- Монголын эдийн засаг 2020 онд 5.4 хувиар агшсан бол, 2021 онд 4.5 хувиар өсөх төсөөлөлтэй байна.
- Өсөлтийг дараах хүчин зүйлс дэмжинэ:
  - Дотоод эдийн засгийг дэмжих бодлогын арга хэмжээнүүд
  - Дэлхийн эдийн засгийн эерэг төлөв
  - Үр дүнтэй вакцинжуулалт
- Эдийн засаг сэргэж байгаа ч өрхийн хэрэглээ 2021 оны эхний хагаст буурлаа. Төсвөөс дэмжлэг олгож байгаа ч 2016 оноос хойш анх удаа ийнхүү буурлаа.

5. Өрхийн хэрэглээ өсөөгүй бол инфляц эрчимжиж байна.

Цалин, хөлстэй холбоотой өрхийн орлого буурсан бол ЗГ-с олгосон орлогын дэмжлэг нь энэ алдагдлыг бараг нөхөөгүй байна.



Цар тахлын шалтгаантай өрхийн амьжиргаанд гарсан өөрчлөлт нь 2021 онд хадгалагдах бол хүнсний үнэ нэмэгдэж байгаа нь ядуу өрхөд хүндээр тусахаар байна. Инфляц 2021 онд дунджаар 6.6 хувьд хүрэх төлөвтэй.



6. Онцлох эрсдэлүүд: Төсвийн тогтвортой байдал

- **Орлого дэмжих арга хэмжээний нөлөөгөөр төсвийн зардал тэлсэн.** Одоогоор хөрөнгийн зардлыг танах байдлаар төсвийн алдагдлыг хязгаарлаж байна. Урт хугацаанд энэ хэвээр үргэлжлэх нь төсвийн тогтвортой байдал, дунд хугацааны өсөлтөд сөргөөр нөлөөлнө
- **Хил дээрх худалдааны асуудал, КОВИД-19-тэй холбоотой эрсдэлүүдээс** шалтгаалан эдийн засгийн сэргэлт удааширч, төсвийн орлого төлөвлөсөн хэмжээнд хүрэхгүй байх эрсдэлтэй.
- **Цар тахлыг хяналтдаа авахгүй бол төсвийн алдагдал** нэмэгдэж, алдагдал тэлэхийн зэрэгцээ төсвийн шинжтэй арга хэмжээнээс шалтгаалан улсын өрийн дарамт улам нэмэгдэх эрсдэлтэй.



7. Онцлох эрсдэлүүд: Инфляц эрчимжиж, төлбөрийн тэнцлийн дарамт нэмэгдэж байна.

Эдийн засгийн өсөлтийг хамгаалах, инфляцыг тогтворжуулах, гадаад валютын нөөцөө хамгаалах аль аль зорилгоо алдагдуулахгүй байх нь гол сорилт болж байна.

- **Төсвийн шинжтэй арга хэмжээг хэрэгжүүлж мөнгөний бодлогыг сулруулах** нь инфляцыг хөөргөдөх эрсдэлтэй тул эдгээр хөтөлбөрөөс аажмаар гарах
- **Хил дээрх саатал нь** гол түүхий эдийн экспортыг хязгаарлаж, импортын зардлыг нэмэгдүүлэх байдлаар төлбөрийн тэнцэлд дарамт болж байна.
- **Төлбөрийн тэнцлийн дарамтыг сааруулж, эдийн засгийн өрсөлдөх чадварыг хадгалах, нөөцийг хамгаалахад** ханшийн уян хатан бодлого чухал ач холбогдолтой.





8. Онцлох эрсдэлүүд: Санхүүгийн салбар

- **Санхүүгийн хяналт шалгалтын хүрээнд тавих шаардлага, шалгуурыг** сулруулах нь тодорхой бус байдал болон цар тахлаас үүдэлтэй дарамтыг нэмэгдүүлэх эрсдэлтэй. Иймд шалгуур үзүүлэлтийг зохистой түвшинд хүргэх арга хэмжээг шат дараатай хэрэгжүүлэх.





Цаашид авах арга хэмжээ ...

1. Вакцинжуулалтыг үргэлжүүлэх, эрүүл мэндийн тогтолцоог бэхжүүлэх, бэлэн байдлыг хангах
2. Тээвэр, ложистикийг сайжруулах замаар КОВИД-19-ийн хязгаарлалттай холбоотой хүндрэлийг даван туулах
3. Цар тахалтай тэмцэх үүднээс авсан арга хэмжээг аажмаар зөөлрүүлэх, улмаар төсөвт ирэх дарамтыг бууруулах
4. Төсвийн шинж чанартай төсөл хөтөлбөрийг хязгаарлах/төсөв рүү шилжүүлэх
5. Санхүүгийн хяналт шалгалтын хүрээнд тавигдах шаардлага болон шалгуур үзүүлэлтийг шат дараатайгаар зохистой түвшинд нь хүргэх
6. Дунд хугацаанд: байгалийн нөөцөөс хэт хамааралтай байдлыг сааруулах, хүний нөөцийн ашиглалтыг дээшлүүлэх, институтийг бэхжүүлэх чиглэлээр бүтцийн шинэчлэл

Баярлалаа.